# НИЙСЛЭЛИЙН
# ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
# ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 11 өдөр　　　　Дугаар А/90　　　　Улаанбаатар хот

"Улаанбаатар хотын хөгжлийн корпораци"
ХК-ийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 25,000,000 (хорин таван сая) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг "Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК (Н.Баярчимэг)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 17 нэр төрлийн 25,000,000 (хорин таван сая) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 25,000,000 (хорин таван сая) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 7,500,000 (долоон сая таван зуун мянган) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг "Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК (Н.Баярчимэг)-д, орлого төвлөрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (П.Магнайбаатар)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА　　　　М.БАЯРАА

1150500009253

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 11 -ны өдрийн A/90 дугаар тушаалын хавсралт

## Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

**Байгууллагын нэр: "Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХХК**

| д/д | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Бүгд үнэ | Байгуулсан элэгдэл (2021.09.30) | Үлдэгдэл үнэ (2021.09.30) | Эвдрэл гэмтэл | ӨХБЗ-ийн дүгнэлт | ЭБХХХК-н шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ханын тавилга (захирлын өрөө) | 6 | ш | 1 | 2,600,730.00 | 2,600,730.00 | 1,633,144.18 | 967,585.82 | Салгаж авбал эвдэрнэ | актлах | 2,600,730.00 |
| 2 | Телевизорын тавиур (захирлын өрөө) | 6 | ш | 1 | 1,262,800.00 | 1,262,800.00 | 792,982.92 | 469,817.08 | | актлах | 1,262,800.00 |
| 3 | Шилэн хана | 6 | ш | 1 | 5,445,472.58 | 5,445,472.58 | 2,731,885.31 | 2,713,587.27 | | актлах | 5,445,472.58 |
| 4 | Мебель хана | 6 | ш | 7 | 643,567.74 | 4,504,974.18 | 2,235,835.68 | 2,269,138.50 | | актлах | 4,504,974.19 |
| 5 | Таазны мебель өнгөлгөө | 6 | ш | 6 | 373,961.11 | 2,243,766.66 | 1,113,589.85 | 1,130,176.81 | | актлах | 2,243,766.67 |
| 6 | Нэг хавтастай хаалга (Захиргаа, удирдлагын газар) | 6 | ш | 1 | 279,053.76 | 279,053.76 | 128,355.98 | 150,697.78 | | актлах | 279,053.76 |
| 7 | Нэг хавтастай хаалга (Төр, хувийн хэвшил, түншлэлийн хэрэгжүүлэлт болон Хөгжүүлэлтийн газрын захирлын өрөө) | 6 | ш | 1 | 279,053.76 | 279,053.76 | 133,244.42 | 145,809.34 | | актлах | 279,053.76 |
| 8 | Нэг хавтастай хаалга (Дэд захирал) | 6 | ш | 1 | 279,053.76 | 279,053.76 | 137,895.32 | 141,158.44 | | актлах | 279,053.76 |
| 9 | Нэг хавтастай хаалга (Дэд захирал-2) | 6 | ш | 1 | 279,053.76 | 279,053.76 | 138,567.95 | 140,485.81 | | актлах | 279,053.76 |
| 10 | Нэг хавтастай хаалга (Агуулах) | 6 | ш | 1 | 279,053.76 | 279,053.76 | 139,995.73 | 139,058.03 | | актлах | 279,053.76 |
| 11 | Нэг хавтастай хаалга (Архив) | 6 | ш | 1 | 279,053.76 | 279,053.76 | 137,197.69 | 141,856.07 | | актлах | 279,053.76 |